

МБСХ СПОРТЫН ХУВЦАСНЫ ЖУРАМ

1. ҮНДСЭН ЖУРАМ

1.1. Энэхүү журмыг МБСХ-ны Тэргүүлэгчдээс ОУБСХ-ны спортын хувцасны шинэ дүрэмд нийцүүлэн боловсруулж, 2003 оны 1-р сарын 10-нд батлав. Дүрэм нь 2003 оны 2-р сарын 1-нээс мөрдөгдөнө. МБСХ-ны гишүүд жил бүрийн 4-р сараас 8-р сар хүртэл энэхүү журамд нэмэлт ба өөрчлөлт оруулах саналаа өгөх эрхтэй.

1.2. Энэхүү журам нь МБСХ-ны бүх бүтцэд хэрэгжих ёстой. Журмыг тэмцээний үндсэн цогц элемент болох клубын тэмцээнээс эхлээд Монгол улсын аварга шалгаруулах, цомын тэмцээн хүртэлх МБСХ-ны тэмцээний бүх төрөл, хэлбэр, шатанд хэрэглэнэ.

1.3. Энэхүү журмыг клубуудад хүргэх, сурталчлах, дүрмийг бүсийн тэмцээнээс эхлээд клубын тэмцээнүүдэд нэн даруй хэрэглэх нь гишүүн байгууллагуудын Тэргүүлэгчдийн үүрэг мөн.

1.4. Энэхүү журмыг бүх насны ангилалын хос бүрд хүргэх, журмыг клубын тэмцээнүүдэд хэрэглэх нь тухайн клубын удирдлага, дасгалжуулагчийн үүрэг мөн.

1.5. МБСХ-ны ба/эсвэл гишүүн байгууллагуудын албаны хүмүүс энэхүү журмыг хэрэгжүүлэх үүргээ үл биелүүлбэл МБСХ-ны Тэргүүлэгчид сахилгын арга хэмжээ авах эрхтэй.

1.6. Тэмцээний үед энэхүү журам хэрэгжиж байгаа эсэхэд ерөнхий шүүгч хяналт тавих үүрэгтэй. Харин түүний эзгүйд тэмцээний зохион байгуулагч хяналт тавина.

1.7. Дүрэм зөрчсөн явдал илэрвэл ерөнхий шүүгч нь тамирчин ба түүний дасгалжуулагчийг тэмцээн эхлэхээс өмнө тэмцээнийг орхихыг шаардах үүрэгтэй. Хэрэв тамирчин шаардлагыг үл биелүүлбэл ерөнхий шүүгч түүний гүйцэтгэх эрхийг тухайн тэмцээнийг дуустал хасах эрх эдэлнэ.

1.8. Клубын тэмцээнээс эхлээд бүсийн тэмцээнүүдэд гүйцэтгэх эрхийг хассан тохиолдол бүрийг ерөнхий шүүгч тухайн клубын удирдлага болон МБСХ-ны Тэргүүлэгчдэд бичгээр мэдээлэх үүрэгтэй.

1.9. Тамирчин эсвэл түүний клубын удирдлагаас гүйцэтгэх эрхийг хассан албан тушаалтны шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд гомдол мэдүүлснээс хойш 14 хоногийн хугацаанд МБСХ-ны Тэргүүлэгчдийн хурлаар авч хэлэлцэнэ. Энэхүү хурлын шийдвэр эцсийнх байна.

1.10. Тамирчны гүйцэтгэх эрхийг улиралд 2 эсвэл түүнээс дээш тэмцээнд хассан тохиолдолд Тэргүүлэгчдээс дараа улирлын дөрвөн тэмцээнд оролцох эрхийг хасах эрхтэй эсвэл түүний харьяа клубт сахилгын арга хэмжээ авна. Олон улсын зэрэглэлийн тамирчны гүйцэтгэх эрхийг хасах асуудлыг МБСХ-ны тэргүүлэгчдээс тусад нь авч хэлэлцэнэ.

2. ҮНДСЭН ОЙЛГОЛТУУДЫН ТОДОРХОЙЛОЛТ

Спортын хувцас гэж олон нийтийн спортын арга хэмжээнүүд дээр хэрэглэгддэг, нийгмийн ёс суртахуун ба гоо зүйн шаардлага, биеийн хөдөлгөөний чөлөөт байдлыг хангасан, тамирчны нас, гүйцэтгэж буй бүжгийн төрлийн онцлогт тохирсон тусгайлан оёсон гадуур хувцсыг хэлнэ. Хувцас нь цогцдоо дараах элементүүдээс бүрдэнэ:

2.1. Жинхэнэ хувцас – тэмцээн явагдаж байх үед үзэгчдийн нүдэнд ил харагдах дээгүүрх хувцасны янз бүрийн элементүүд, доогуурх хувцасны тусгай хэсгүүд (оймс, урт оймс, богино өмд)

2.2. Хувцасны засал – хувцасны үндсэн даавуу ба аксессуар дээр бусад материалаар хатгасан хээ угалз, хуниас, санжуурга, оосор, утас, цацаг, тэмээн хяруул, марабу болон бусад шувууны өд сөд, боа зэрэг амьтдын үс, гялтгануур, чулуу, товч, сувд, өнгийн шил, товруу, даруулга, хиймэл болон амьд цэцэг, бусад ургамал, жимс г.м

2.3. Костюмын аксессуарууд – толгойн гоёл, толгойн боолт, бүч, гурвалжин болон том алчуур, хүзүүний ороолт, хүзүүний алчуур, бээлий, бүс, мөрөвч, чагтан товч г.м

- 2.4. Гутал – эрэгтэй эмэгтэй тусгай гутал, задгай сандаал
- 2.5. Чимэглэл – уран хийцтэй эдлэл: титэм, гоёлын залаа, үсний хатгуур, ээмэг, сүйх, хүзүүний зүүлт, гинж, цагариг, эрдэнийн чулуу, гоёлын зүү, хатгуур
- 2.6. Бугуйвч - цаг, цагариг, шигтгээтэй бугуйвч г.м
- 2.7. Макияж – төрөл бүрийн гоо энгэсэг, мэйк-ап, нүүрний энгэсэг, нүүр биеийн үндсэн тон, зохиомол борлуулагч, хөмсөг сормуусны будаг, сүүдэр, гялтганууртай түрхэц будаг, уруулын будаг, хумсны өнгөт лак, хиймэл сормуус, хиймэл хумс г.м
- 2.8. Үс засалт - өөрсдийн үсний янз бүрийн загварын тайралт, хяргалт, хонгорцог, туг үс, сүлжсэн гээг, боосон үс – “сүүл”, хиймэл парик г.м

Тайлбар: Бүжгийн хувцасны элементүүдийн тухай дээр дурьдсан тайлбар бүрэн төгс биш бөгөөд шаардлагын хэмжээгээр нэмж болно.

3. ҮНДСЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ ЗҮЙЛС БА ХЯЗГААРЛАЛТ

- 3.1. Бүх насны хосууд, Стандарт/Латин
 - 3.1.3. Хувцас зохимжгүй эсвэл ашиглагдах боломжгүй болохоос бусад тохиолдолд тэмцээний үед хувцсаа сольж өөрчилж болохгүй.
 - 3.1.4. Гоёл чимэглэлийн зорилгоор шашны эд зүйлс ашиглахыг хориглоно.
 - 3.1.5. ОУБСХ-ны дүрмийн дагуу реклам байрлуулахыг зөвшөөрнө.
 - 3.1.6. Тамирчны чимэглэл түүнд өөрт нь болон орчин тойрондоо аюул учруулахаар бол ерөнхий шүүгч авахыг шаардах эрхтэй.
- 3.2. Бүх насны эмэгтэй, Стандарт/Латин
 - 3.2.1. Хувцас болон богино өмдний өнгө, загвар нь дурын байж болно. Гагцхүү нүцгэн байгаа мэт сэтгэгдэл төрүүлж болохгүй.
 - 3.2.2. Бүжгийг гүйцэтгэж байх үед өгзөг, хондлой бүрэн халхлагдаж байх ёстой.
 - 3.2.3. Дараах зүйлсийг хориглоно:
 - 3.2.3.3. Таз хэвлийн урд ба хажуу хэсгийг нүцгэлсэн tangas загварын богино өмд өмсөх
 - 3.2.3.4. Таз хэвлийн урд хэсгийг нүцгэлэх
 - 3.2.3.5. Усны саланги хэлбэрийн хувцас (хөхний даруулга-богино өмд, хөхний даруулга-банзал, богино майк-богино өмд, богино майк-банзал) өмсөх
- 3.3. Бүх насны эрэгтэй, Стандарт/Латин
 - 3.3.3. Дараах зүйлсийг хориглоно:
 - 3.3.1.3. Хувцас – Цамц өмдний үндсэн материал болгож өнгөгүй болон торон материал ашиглах. Харин өнгөгүй болон торон материалыг багавтар оруулга болгон ашиглахыг зөвшөөрнө.
 - 3.3.1.4. Аксессуар – Ямар ч даавуун болон бусад материалаар хийсэн толгойн гоёл, бээлий, толгойн боолт, гурвалжин алчуур
 - 3.3.1.5. Чимэглэл – Ээмэг, зүүлт, гоёлын зүү, хатгуур, амьд болон хиймэл цэцэг, бусад ургамал жимс
 - 3.3.1.6. Макияж – Энгэсэг, уруулын будаг, зовхины сүүдэр, хиймэл сормуус, хөмсөг, сормуусны будаг, хумсны лак
 - 3.3.1.7. Үс засалт – Сахал, хонгорцог, туг үс, гээг. Боосон үс-“сүүл”-ийг зөвшөөрнө.

4. ХҮҮХЭД НАС-1 /JUVENILES-1 (9 НАС ТҮҮНЭЭС БАГА)

5-р бүлэгт заагдсан журам үйлчилнэ.

Мөн 3-р бүлэгт заагдсан заалтууд үйлчилнэ.

5. ХҮҮХЭД НАС-2/ JUVENILES-2 (10-11 НАС)

5.1. ЭРЭГТЭЙ, Стандарт/Латин

5.1.1. Дараах зүйлс заавал байх ёстой:

5.1.1.1. Хар өмд, хар өнгийн тэлээ (металл тольтой байж болно)

5.1.1.2. Энгийн (фракны биш) урт ханцуйтай хөвөн даавуу эсвэл хагас хөвөн даавуун цагаан өнгийн цамц. Цамцыг заавал индүүдсэн байна.

5.1.1.3. Хар зангиа эсвэл хар эрвээхэй. Зангианы металл хавчаар хэрэглэхийг зөвшөөрнө.

5.1.1.4. Намхан өсгийтэй хар өнгийн ширэн эсвэл илгэн гүтал. Хар өнгийн оймс

5.1.1.5. Үсийг богино засуулсан эсвэл боосон-“сүүл”

5.1.2. Дараах зүйлсийг хориглоно:

5.1.2.1. Гялалздаг болон хээ угалзтай даавуун материал ашиглах. Зах энгэрийг задгайлах, ханцуйг нугалах

5.1.2.2. Хувцсыг чимэглэх, нүүрийг будах-макияж, эрдэнийн зүйлс-чимэглэл хэрэглэх

Мөн 3-р бүлэгт заагдсан заалтууд үйлчилнэ.

5.2. ЭМЭГТЭЙ, Стандарт/Латин

5.2.1. Дараах сонголтуудыг зөвшөөрнө:

5.2.1.1. Хар өнгийн банзал цагаан цамцны хамт

5.2.1.2. Хар өнгийн банзал балетийн урт ханцуйтай цагаан триконы хамт (боди)

5.2.1.3. Хар өнгийн банзал богино ханцуйтай цагаан майкны хамт

5.2.1.4. Энгийн нэг өнгийн даашинз

5.2.1.5. Балетийн урт ханцуйтай трико, банзал

5.2.2. Банзал болон даашинзны хормойн эсгүүрийн зураглал: Банзал нь энгийн эсвэл хоёр болон гурван хагас наран хуниастай байна. Хуниасгүй дотуур банзал өмсөхийг зөвшөөрнө. Банзлын доод ирмэг өвдөгнөөс 10 см-ээр дээш эсвэл доош байж болохгүй.

5.2.3. Дараах зүйлсийг зөвшөөрнө:

5.2.3.1. Нэг өнгийн хэд хэдэн төрлийн даавуун материалыг хослуулах. Хувцасны бүх элементүүд биеийн өнгөнөөс бусад өнгийнх байж болно.

5.2.3.2. Гялалздаггүй материалаар хатгамал, засал хийж болно.

5.2.3.3. Хоёр төрөлд 3,5 см-ээс өндөргүй зузаан өсгийтэй нэг гүтал өмсөх

5.2.3.4. Биеийн өнгөтэй бүжгийн тусгай оймс эсвэл өвдөгнөөс дээшгүй цагаан оймс

Эсгүүрийн зөвшөөрөгдсөн загварыг 1-р хавсралтаас харна уу,

5.2.4. Дараах зүйлсийг хориглоно:

5.2.4.1. Гялалздаг, металл өнгийн, биений өнгийн болон өнгөгүй даавуун материал

5.2.4.2. Гялтгануур, чулуу, сувд, өнгийн шил, тэмээн хяруул, марабу болон бусад шувуудын өд сөд, амьтдын үс зэрэг засал чимэг

5.2.4.3. Аксессуарууд

5.2.4.4. Эрдэнийн чимэглэл, уран хийцийн эдлэл

5.2.4.5. Хиймэл сормуус, хиймэл хумс, үсний болон хумсны өнгийн лак, зохиомол борлуулагч зэрэг макияж

5.2.4.6. Томчуудын хэв маягаар янзалсан үсний засалт

5.2.4.7. Торон оймс

6. ӨСВӨР НАС-1/ JUNIORS-1 (12-13 НАС)

6.1. ЭРЭГТЭЙ, Латин

6.1.1. Дараах сонголтуудыг зөвшөөрнө:

6.1.1.1. 5-р бүлэгт заагдсан (Хүүхэд нас-2) хувцас

6.1.1.2. Хар эсвэл хар хөх өнгийн өмд, хар тэлээ (металл тольтой байж болно). Хар эсвэл хар хөх өнгийн хантааз, урт ханцуй, цагаан товч, энгийн захтай (фракны биш) задгай

энгэргүй, хээ угалз, хуниас, хатгамал, гялтгануур, чулуу, сувд, өнгийн чулуугүй цагаан өнгийн цамцны хамт. Хэрэв зангиа зүүвэл зангианы металл хавчаар хэрэглэж болно.

6.1.2. Заавал байх ёстой зүйлс:

6.1.2.1. Намхан өсгийтэй хар өнгийн гутал, хар өнгийн оймс

6.1.3. Дараах зүйлсийг хориглоно:

6.1.3.1. Цамцыг задгай тавих, ханцуйг нугалах

6.1.3.2. Ямар нэг материал, элементээр хувцсыг чимэглэж засах

6.1.3.3. Хувцсыг гялалздаг, металл өнгийн даавуугаар оёх

6.1.3.4. Нүүр будаг-макияж

6.1.3.5. Уран хийцийн эдлэл, чимэглэл

6.2. ЭРЭГТЭЙ, Стандарт

6.2.1. Дараах зүйлс заавал байна:

6.2.1.1. Хар эсвэл хар хөх өнгийн өмд

6.2.1.2. Намхан өсгийтэй хар гутал, хар оймс. Үсний богино засалт эсвэл боосон үс-“сүүл”

6.2.2. Мөн дараах сонголтуудыг зөвшөөрнө:

6.2.2.1. Хантааз, урт ханцуйтай цагаан өнгийн цамц, хар өнгийн зангий эсвэл хар эрвээхэй. Хэрэв зангиатай бол зангианы металл хавчаар, чагтан товч хэрэглэж болно.

6.2.2.2. Энгийн зах, цагаан товч, цагаан эрвээхэйтэй, задгай энгэргүй, хуниас, хээ угалз, хатгамал, гялтгануур, чулуу, сувд, өнгийн чулуугүй цагаан өнгийн цамц

6.2.3. Дараах зүйлсийг хориглоно:

6.2.3.1. Цамцыг задгай тавих, ханцуйг нугалах

6.2.3.2. Хувцсыг чимэглэх

6.2.3.3. Нүүр будаг-макияж

6.2.3.4. Уран хийцийн эдлэл, чимэглэл

6.3. ЭМЭГТЭЙ, Стандарт/Латин

6.3.1. Дараах сонголтуудыг зөвшөөрнө:

6.3.1.1. 5-р бүлэгт заагдсан (Хүүхэд нас-2) хувцас

6.3.1.2. Бүжгийн төрөлд зохицсон тэмцээний чимэглэлгүй даашинз. Янз бүрийн өнгөтэй цацаг, залаа, хөвөөтэй даавуун материал ашиглаж болно. Даашинзны уртыг 2-р хавсралтад зааж өгсөн болно. Даашинз нь биеийн өнгөнөөс бусад дурын өнгөтэй байж болно. Богино өмд нь даашинзны өнгөтэй байх ёстой. Гутал: Кубын туфлийг оймсгүй өмсч болно. Үс засалт, макияж: 5-р бүлэгт заасны адил (Хүүхэд нас-2)

6.3.2. Дараах зүйлсийг хориглоно:

6.3.2.1. Өмд

6.3.2.2. Металл өнгийн, гялалздаг, өнгөгүй материал болон биеийн өнгөтэй даавуун материал, торон оймс

6.3.2.3. Гялтгануур, сувд, чулуу, өнгийн шилэн засал, тэмээн хяруул, марабу болон бусад шувууны өд сөд, бао зэрэг амьтдын үс

6.3.2.4. Уран хийцийн эдлэл, чимэглэл

Мөн 3-р бүлэгт заагдсан заалтууд үйлчилнэ.

Тайлбар: Нэг тэмцээн дээр Өсвөр насны ангилалуудыг нэгтгэж оролцуулбал Өсвөр нас-2-ын дүрмийг ашиглана.

7. ӨСВӨР НАС-2/JUNIORS-2 (14-15 НАС)

7.1. ЭРЭГТЭЙ, Стандарт

7.1.1. Дараах сонголтуудыг зөвшөөрнө:

7.1.1.1. Хар эсвэл хар хөх өнгийн өмд, мөн өнгийн хантааз, урт ханцуйтай цагаан өнгийн цамц, хар өнгийн зангиа эсвэл цагаан эрвээхэй

7.1.1.2. Хар эсвэл хар хөх өнгийн өмд, мөн өнгийн пиджак, урт ханцуйтай цагаан өнгийн цамц, хар өнгийн зангиа эсвэл цагаан эрвээхэй

7.1.1.3. Хар эсвэл хар хөх өнгийн фрак бүх аксессуаруудын хамт (цардмал өвчүү, цагаан эрвээхэй, куммербунд г.м)

7.1.2. Дараах зүйлсийг зөвшөөрнө:

7.1.2.1. Зангианы металл хавчаар

7.1.2.2. Намхан өсгийтэй хар өнгийн гутал, хар оймс

7.1.2.3. Богино үс засалт эсвэл боосон үс-“сүүл”

Мөн 3-р бүлэгт заагдсан заалтууд үйлчилнэ.

7.2. ЭРЭГТЭЙ, Латин

7.2.1. Дараах сонголтуудыг зөвшөөрнө:

7.2.1.1. 6-р бүлэгт заагдсан хувцас (Өсвөр нас □)

7.2.1.2. 9-р бүлэгт заагдсан хувцас (Насанд хүрэгчид)

Мөн 3-р бүлэгт заагдсан заалтууд үйлчилнэ.

7.2.2. Дараах зүйлсийг хориглоно:

7.2.2.1. Хувцсыг гялалздаг, металл өнгийн даавуун материалаар оёх

7.3. ЭМЭГТЭЙ, Стандарт/Латин

7.3.1. Дараах сонголтуудыг зөвшөөрнө:

7.3.1.1. 6-р бүлэгт заагдсан хувцас (Өсвөр нас □)

7.3.1.2. 9-р бүлэгт заагдсан хувцас (Насанд хүрэгчид)

Мөн 3-р бүлэгт заагдсан заалтууд үйлчилнэ.

8. ЗАЛУУЧУУД/ YOUTH (16-18 НАС)

9-р бүлэгт заагдсан журам бүрэн үйлчилнэ.

Мөн 3-р бүлэгт заагдсан заалтууд үйлчилнэ.

9. НАСАНД ХҮРЭГЧИД/ ADULTS (16-18 НАС)

9.1. ЭРЭГТЭЙ, Стандарт

9.3.2.1. Заавал өмсөх зүйлс:

9.1.1.1. Хар болон хар хөх өнгийн фрак, цагаан цардмал цээживч, цагаан эрвээхэй, хар оймс, хар өнгийн гутал

9.1.1.2. Засал (хуниас, хатгамал, унжлага), аксессуар (бүс, мөрөвч, татлага, чагтан товч г.м), чимэглэл

9.2. ЭРЭГТЭЙ, Латин

9.2.1. Дараах сонголтуудыг зөвшөөрнө:

9.2.1.1. Хар өнгийн өмд хар цамцны хамт

9.2.1.2. Хар хөх өнгийн өмд хар хөх цамцны хамт

9.2.1.3. Хар эсвэл хар хөх өнгийн өмд цагаан цамцны хамт

9.2.1.4. Хар эсвэл хар хөх өнгийн өмд партнерийн хувцасны ижил өнгийн цамцны хамт

9.2.2. Дараах зүйлсийг мөн зөвшөөрнө:

9.2.2.1. Өмдний өнгөтэй жилет, жакет

9.2.2.2. Цээжнээс дээш задгай тавьсан цамц

9.2.2.3. Хувцасны багавтар хэсгийг тунгалаг материалаар чимэх

9.2.2.4. Нэг өнгийн янз бүрийн даавуун материал хослуулах

9.2.2.5. Өмдийг түүнтэй ижил өнгийн чимэглэлээр чимэх

9.2.2.6. Цамцыг түүнтэй ижил өнгийн чимэглэлээр чимэх

9.2.2.7. Цамц эсвэл өмдний өнгөтэй зангиа, эрвээхэй, хүзүүний ороолт

9.2.2.8. Цамцанд зохицсон хүзүүний ороолт, хүзүүний алчуур

9.2.2.9. Өмдний өнгөтэй бүс, тэлээ

9.2.2.10. Бие болон нүүрэн дээр зөвхөн үндсэн тон, урлагийн загар тавих

9.2.2.11. Үсний богино засалт эсвэл боосон үс-“сүүл”

9.2.3. Дараах зүйлсийг хориглоно:

9.2.3.1. Дөрөвний гурав хэмжээний урттай ханцуйтай, тохойгоор татсан эсвэл тохойноос дээш ханцуйтай ба ханцуйгүй цамц, майк

9.2.3.2. Цамцыг гадуур нь сул тавих

9.2.3.3. Хувцсыг гялалздаг, металл өнгийн даавуугаар оёх

9.2.3.4. Гээг эсвэл хонгорцог үс

Мөн 3-р бүлэгт заагдсан заалтууд үйлчилнэ.

9.3. ЭМЭГТЭЙ, Стандарт

9.3.1. Дараах зүйлсийг зөвшөөрнө:

9.3.1.1. Чимэглэл бүхий тэмцээний даашинз. Цээжний хэсэг бүхэлдээ халхлагдсан байна.

9.3.1.2. Даашинз нь биеийн өнгөнөөс бусад дурын өнгөтэй байж болно. Богино өмд нь даашинзны өнгөтэй байна.

9.3.1.3. Гутал: хязгаарлалт байхгүй.

9.3.2. Дараах зүйлсийг хориглоно:

9.3.2.1 Хоёр тусгай хэсгээс бүрдсэн даашинз

9.3.2.2 Бэлхүүснээс доош гаргасан ухаадас, онь. Ханцуйгүй, задгай даашинз

9.3.2.3 Бэлхүүснээс доош өнгөгүй даавуун материал ашиглах

9.3.2.4 Косметикийг хэтрүүлэн хэрэглэх

Мөн 3-р бүлэгт заагдсан заалтууд үйлчилнэ.

9.4. ЭМЭГТЭЙ, Латин

9.4.1. Дараах зүйлсийг зөвшөөрнө:

9.4.1.1. Тэмцээний даашинз. Хувцасны эсгүүрийг 2-р хавсралтанд заасан болно.

9.4.1.2. Ташаа, гуяны дотор тал, цээжний хэсэг бүхэлдээ халхлагдсан

9.4.1.3. Гуяны шугам дунд чөмөгний өндрийн дагууд халхлагдсан

9.4.1.4. Тайван үед банзал нь богино өмдийг бүрэн халхалсан

9.4.1.5. Даашинз хоёр хэсгээс бүрдсэн бол даашинзны дээд хэсэг хөхний даруулга мэт харагдахааргүй байх ёстой.

9.4.1.6. Биеийн өнгөнөөс бусад дурын өнгөтэй байж болно. Богино өмд нь даашинзны ижил өнгөтэй эсвэл хар өнгөтэй байна.

9.4.1.7. Гутал: хязгаарлалт байхгүй.

Мөн 3-р бүлэгт заагдсан заалтууд үйлчилнэ.

10. АХМАД НАС/ SENIORS (35 НАС БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ)

9-р бүлэгт заагдсан журам бүрэн үйлчилнэ.

Мөн 3-р бүлэгт заагдсан заалтууд үйлчилнэ.

11. ШҮҮГЧДИЙН ХУВЦАС

11.1. Оройн арга хэмжээн дээр:

11.1.1. Эрэгтэйчүүд

11.1.1.1. Хар өнгийн смокинг. Латин бүжгийн тэмцээн дээр цагаан болон бусад өнгийн смокингийг зөвшөөрнө.

11.1.1.2. Клубын тэмцээн дээр зангиа, оройн костюм

11.1.2. Эмэгтэйчүүд

11.1.2.1. Оройн даашинз эсвэл оройн костюм

11.2. Өглөөний болон өдрийн арга хэмжээнд:

11.2.1. Эрэгтэйчүүд:

11.2.1.1. Смокинг (11.1-д заасан) эсвэл ердийн костюм. Ерөнхий шүүгч, зохион байгуулагчид нь шүүгчдийг смокинг эсвэл костюм зэрэг нэгдсэн хувцсаар хангах үүрэгтэй.

11.2.2. Эмэгтэйчүүд

11.2.2.1. Албаны даа шинз эсвэл костюм. Өдөр тутмын хувцас өмсөхийг хориглоно.